ДАМЖУУЛАН ОЛГОХ ТӨСЛИЙН ЗЭЭЛҮҮДИЙН 2019 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРЛЫН ТАЙЛАН

Монголбанкнаас дамжуулан олгож буй төслийн зээлүүдийн тайланг улирал бүр гаргаж, Монголбанкны вэб хуудсанд байршуулах ажлын хүрээнд 2019 оны 4 дүгээр улирлын тайланг танилцуулж байна.

Монгол улсын Засгийн газар 1994 онд Азийн хөгжлийн банктай, 1995 онд ХБНГУ-ын Засгийн газартай байгуулсан гэрээний дагуу Монголбанк КфВ банк болон АХБ-ны төслийн зээлийг банкуудад дамжуулан олгох үүрэгтэй оролцож байна.

1. КфВ банкны ЖДҮ-ийг дэмжих төслийн зээл

Төслийн зорилго: Боловсруулах үйлдвэрлэл, Хөдөө аж ахуйн чиглэлийн ЖДҮ-ийг хөгжүүлэх, санхүүгийн секторыг дэмжих.

Эх үүсвэр: Монгол Улс, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу 40 жилийн хугацаатай 8.7 сая еврогийн зээлийг жилийн 0.75 хувийн хүүтэйгээр хүлээн авсан.

КфВ банкнаас Монголбанкинд олгосон зээлийн эргэн төлөлт: Монголбанк КфВ банкинд жилд 2 удаа хуваарийн дагуу эргэн төлөлт хийдэг бөгөөд анх зээл авсанаас хойш нийт 3.4 сая еврог КфВ банкинд төлсөн. Ингэснээр энэхүү зээлийн үлдэгдэл 2019 оны 4 дүгээр улирлын эцсийн байдлаар 5.3 сая евро байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. КфВ төслийн зээлийн эргэн төлөлт, үлдэгдэл, еврогоор

	2019.I	2019.II	2019.III	2019.IV
Эхний үлдэгдэл	5,618,006.65	5,618,006.65	5,476,154.78	5,476,154.78
Үндсэн зээлийн төлбөр	-	141,851.87	-	141,851.87
Хүүгийн төлбөр	-	21,067.52	-	20,535.58
Эцсийн үлдэгдэл	**5,618,006.65**	**5,476,154.78**	**5,476,154.78**	**5,334,302.91**

Монголбанкнаас Банкинд олгосон зээл: Монголбанк 500 000 000 төгрөг хүртэлх санхүүжилтийг 5 жилийн хугацаатай зээлийг төсөлд оролцогч ХХБ, Голомт, УБХБ, Капитрон, Тээвэр хөгжлийн банкуудаар дамжуулан олгодог. Төсөлд оролцогч банкуудад олгосон зээлийн үлдэгдэл 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1.9 сая евро буюу 5.7 тэрбум төгрөг* байна. Харин КфВ төслийн ашиглаагүй эх үүсвэрийн үлдэгдэл 2019 оны 4 дүгээр улирлын эцсийн байдлаар 3.4 сая евро буюу 10.6 тэрбум төгрөг* байна (Зураг1).

Зураг 1. КфВ төслийн санхүүжилтийн үлдэгдэл, сая еврогоор



*2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн ханшаар тооцов.

Банкуудын ААН-д олгосон зээл: КфВ банкны төсөл манай улсад хэрэгжиж эхэлснээс хойш уг төсөлд нийт 171 ЖДҮ зээлд хамрагдаж, 87.6 тэрбум төгрөг*-ийн хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл авсан байна.Тайлант улирлын эцсийн байдлаар 44 ЖДҮ эрхлэгч ААН-үүд 5.8 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Нэг зээлдэгчид ногдож буй зээлийн дундаж хэмжээ 131.3 сая төгрөг байна.

2. АХБ-ны Ажлын байр нэмэгдүүлэх (АБН) төслийн зээл

Төслийн зорилго: Монгол улс, АХБ-ны хооронд байгуулсан зээлийн хэлэлцээрийн зорилго нь хувиараа хөдөлмөр эрхлэх хэлбэрээр жижиг үйлдвэрлэл эрхэлж буй иргэдийг дэмжих, мөн ажлын байр нэмэгдүүлэхэд оршино.

Эх үүсвэр: Монгол Улс, Азийн хөгжлийн банкны хооронд байгуулсан хэлэлцээрийн дагуу 2154.0 мянган зээлжих тусгай эрхтэй (ЗТЭ) тэнцэх валютыг 40 жилийн хугацаатай зээлсэн.

АХБ-наас Монголбанкинд олгосон зээлийн эргэн төлөлт: Монголбанк АХБ-нд жилд 2 удаа хуваарийн дагуу эргэн төлөлт хийдэг. Анх зээл авснаас хойш нийт 1012.1 мянган ЗТЭ-ийг төлсөнөөр 2019 оны 4 дүгээр улирлын эцсийн байдлаар зээлийн өрийн үлдэгдэл 1,141.9 мянган ЗТЭ буюу 4.1 тэрбум төгрөг* байна (Хүснэгт 2).

Хүснэгт 2. АХБ-ны АБН төслийн зээлийн эргэн төлөлт, үлдэгдэл /ЗТЭ/,

	2018.IV	2019.I	2019.II	2019.III	2019.IV
Эхний үлдэгдэл	1,223,517.68	1,223,517.68	1,182,717.68	1,182,717.68	1,141,917.68
Үндсэн зээлийн төлбөр	-	40,800.00	-	40,800.00	-
Хүүгийн төлбөр	-	6,117.59	-	5,913.59	-
Эцсийн үлдэгдэл	**1,223,517.68**	**1,182,717.68**	**1,182,717.68**	**1,141,917.68**	**1,141,917.68**

Банкинд дамжуулан олгосон зээл: Монголбанк эцсийн зээлдэгчид 30 хүртэлх сая төгрөгийн санхүүжилтийг 2 жилийн хугацаатайгаар төсөлд оролцогч Голомт, Улаанбаатар хотын банк, Ариг, Богд банкуудаар дамжуулан олгодог. Тайлант улирлын эцсийн байдлаар төслийн хүрээнд банкуудад дамжуулан олгосон эх үүсвэрийн үлдэгдэл 2.3 тэрбум төгрөг байгаа бөгөөд эргэлтийн санд зээлдүүлэх боломжит эх үүсвэр 2.0 тэрбум төгрөг* байна (Зураг 2).

Зураг 2. АХБ-ны АБН төслийн зээлийн үлдэгдэл, ашиглагдаагүй эх үүсвэр

*2019 оны 12 дүгээр сарын 31-ний өдрийн ханшаар тооцов.

Банкуудын тайлангаас үзэхэд 2019 оны 4 дүгээр улирлын байдлаар үлдэгдэлтэй байгаа 87 зээлдэгч нийт 266 ажлын байр шинээр бий болгохоор байна**.**